



“ХУРД ХОЛДИНГ” ХХК-д

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

14251 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
II хороо, Чингисийн өргөн чөлөө 11
Утас: 62263168, Факс: (976-11) 31-23-15
И-мэйл: info@mrttd.gov.mn, <https://www.mrttd.gov.mn>

2016.08.30 № 38-07-002/02

Шаардлага хангасан тухай

Танай 2016 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн Б/796 тоот албан бичгээр тавьсан хүсэлтийн дагуу мэргэшсэн жолооны сургалт явуулах сургалтын боловсон хүчин, материаллаг бааз, тээврийн хэрэгслүүдэд 2016 оны 08 дугаар сарын 26-ны өдөр захирал О.Баярцогтыг байцуулан хяналт хийлээ.

1. Компанийн тухай ерөнхий мэдээлэл

Тус компанийн “Баянбулаг” авто сургууль 1999 онд байгуулагдаж, 2000 оноос хойш тасралтгүй 16 дахь жилдээ авто жолооны сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа ба 2005 онд “Шилдэг авто сургууль”, 2010 онд “Шилдэгийн шилдэг авто сургууль”-аар шалгарч байсан байна. Улсын бүртгэлийн дугаар 9011047005, Регистр 2691957.

2. Тодорхойлох нь:

Боловсон хүчний хувьд:

Сургалтын багш нийт 5. Үүнээс:

1. Автотээврийн тухай хууль түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм, журам, стандарт, Замын хөдөлгөөний тухай хууль, дүрэм, замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр хичээл заах багш/Д.Мөнхбат/-1;

2. Мэргэшсэн жолоочийн жолоодлогын сургалтад:

- “В” ангиллын мэргэшсэн жолооны багш/О.Баярцогт/-1;
- “Д” ангиллын мэргэшсэн жолооны багш/Ж.Батхуяг/-1;
- “Е” ангиллын мэргэшсэн жолооны багш/Б.Ганбаатар/-1;
- “С” ангиллын мэргэшсэн жолооны багш/Ж.Батчулуун/-1

Материаллаг бааз:

БГД-ийн 10 хорооны нутаг дэвсгэрт байрлах, 45 м² талбай бүхий дүрмийн сургалтын танхимд үйл ажиллагаа эрхлэх, 324 м² үйлчилгээ, гараашийн зориулалтын байр зэрэг материаллаг баазтай байна. Мөн БГД 20 хороонд байрлах “Их үүсгэл” ХК-ийн өмчлөлийн 4600 м² талбайг жолооны сургалтын дадлагын зориулалтаар ашиглах “Талбай түрээслэр гэрээ”-г 2014 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 2019 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл байгуулж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тээврийн хэрэгслийн хувьд:

Нийт сургалтад 27 тээврийн хэрэгсэл ашиглаж байгаагаас мэргэшсэн жолоочийн сургалтад Хьюндай Соната-7 маркийн/3366 УНП/ суудлын-1, Хьюндай Аеро city-540 маркийн/2477 УБЕ/ том оврын автобус-1, ЗИЛ 130 маркийн/0091 УНС, 0500 УБӨ, 0159 УББ/ ачааны-2 тээврийн хэрэгслийн насжилт дунджаар 24.2 жил байна.

08 006

Дүгнэх нь:

1. Танай компанийн багш, тээврийн хэрэгсэлүүд мэргэшсэн жолоочийн сургалт эрхлэх стандартын шаардлага **“Хангасан”**;
2. Цаашид сургалтад ашиглаж буй тээврийн хэрэгслийн насжилтийг багасгах арга хэмжээ авах шаардлагатай гэж дүгнэлээ.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

АВТОТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ



Д.ЭНХ-АМГАЛАН

ДҮГНЭЛТ ХҮЛЭЭН АВСАН:

“ХУРД ХОЛДИНГ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



О.БАЯРЦОГТ